## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 13 Улаанбаатар хот

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин | Төсөв (сая төг) | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | 4.1.1.11.Визийн зөрчилтэй гадаад иргэдийн тоог бууруулж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно. | Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах систем болон Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн систем хооронд мэдээлэл харилцан солилцох | 2025 - 2028 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | 320.00 | - | 20 | 140.00 | 120.00 | “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем (ISF)-д нэмэлт хөгжүүлэлт хийх” тендер шалгаруулалтыг 04 дүгээр сарын 24-ний өдөр зарлаж, шалгарсан аж ахуйн нэгжтэй 120,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ГИХГ/20250103004/01/06-18 дугаар гэрээг 05 дугаар сарын 21-ний өдөр байгуулан гэрээний хүрээнд “Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах систем”-тэй мэдээлэл солилцохоор хөгжүүлж байна. https://www.tender.gov.mn/ mn/invitation/detail/1743570117880 | |
| 2 | | Оршин суух үнэмлэх хэвлэх цэгийг нэмэгдүүлэх | 2025 - 2026 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын төсөв, Гадаадын зээл, тус | 500.00 | 1 | 4 | 250.00 | 0.00 | Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд олгох оршин суух үнэмлэх хэвлэх 1 киоск төхөөрөмжийг Эдийн засаг, хөгжлийн яамны хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвд байршуулж, 02 дугаар сарын 20-ны өдрөөс | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ламж | | | | | | үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн оршин суух үнэмлэх хэвлэх 1 ширхэг төхөөрөмжийг Гадаад харилцааны яаманд хүлээлгэн өгсөн бөгөөд тус яамны Ёслолын газарт дипломат албан, хаагчдын оршин суух үнэмлэхийг хэвлэж байна. Хагас жилийн байдлаар дээрх үйл ажиллагаанд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно. | |
| 3 | | Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт тоон гарын үсэг олгох | 2025 - 2027 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын төсөв, Гадаадын зээл, тус ламж | 350.00 | - | 40 | 100.0 | 0.00 | Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт тоон гарын үсэг олгох зорилгоор FS100110_nonGovernmentalOrganizationInfo сервисийг шинээр хөгжүүлэн Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гаргасан бөгөөд тоон гарын үсэг олгогч Ньюкомпас скэй ХХК-аас 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн шаардлагад нийцүүлэн гаралтын утгыг шинэчлэн хөгжүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно. | |

--oo0o--